

ХАНБОГД СУМЫН
ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ



ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 ОН

АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

1-Р БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ

- 1.1 Зөвлөлийн удирдлага
- 1.2 Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн
- 1.3 Зохион байгуулсан хурал, сургалт арга хэмжээ
- 1.4 Зөвлөх үйлчилгээ, хяналт үнэлгээ
- 1.5 Мэдээллийн ил тод байдал
- 1.6 Санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал

2-Р БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 2.1. Хөөн хэлэлцэх нөхөн олговор
- 2.2 Тайлант онд зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ
 - 2.2.1 “Эрүүл малчин-3” хөтөлбөр
 - 2.2.2 Усжуулалт
 - 2.2.3 Малчдын хороо бууц засварын ажил
 - 2.2.4 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр
 - 2.2.5 Малчны зах, мал нядалгааны зам байгуулах төсөл
- 2.3 Тогтвортой амьжиргааны төсөл хөтөлбөр
- 2.4 Ундайн голын өв соёл төсөл
- 2.5 Мониторинг

Хавсралт 1. Гэрээний хэрэгжилт 2022 он

МЭНДЧИЛГЭЭ

Та бүхэндээ Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж буйдаа баяртай байна.



С.ДОРЖДЭРЭМ

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН
АХЛАГЧ, “ОЮУТОЛГОЙ” ХХК-ИЙН
ОРОН НУТГИЙН ХАРИЛЦААНЫ
ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР



Х.ОТГОНЖАРГАЛ

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН
УДИРДАХ НЭГЖИЙН ГИШҮҮН,
ХАНБОГД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ



Ч.НАМНАНСҮРЭН

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН
УДИРДАХ НЭГЖИЙН ГИШҮҮН,
ХАНБОГД СУМЫН ЖАВХЛАНТ
БАГИЙН МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ

Тайлант онд Гурван талт зөвлөлийн талууд, гишүүд, малчид, хамтрагч байгууллагууд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ний хэрэгжилтийг хангахын төлөө тууштай хамтран ажиллалаа. 2022 онд гэрээний хэрэгжилтийг үнэлж үзэхэд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-нд тусгагдсан нийт 64 ажлаас 26 ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. Өмнөх онуудад амжилттай хэрэгжсэн зарим төслүүдийг ГТЗ-өөр зөвшилцөн хэлэлцсэний үндсэн дээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. 2021-2022 онд ГТЗ-ийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын хувьд шинэ шатанд гаргах олон ажлуудыг санаачлан хэрэгжүүллээ. ГТЗ-ийн дүрэмд заасны дагуу хариуцлагатай, ёс зүйтэй, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нам улс төрөөс ангид байх зарчмыг баримталж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “ГТЗ-ийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам” батлан хэрэгжүүлж эхэлсэн. Мөн ГТЗ-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд ГТЗ-ийн албан ёсны цахим хуудас, фейсбүүк хаяг нээж сонирхогч талуудад мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд ихээхэн анхаарсан жил байлаа. ГТЗ-ийн дүрмийн хэрэгжилт буюу засаглалын үр дүнтэй байдал, “Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2”-т туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хараат бус хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг ирэх онд хийлгэхээр зөвлөлийн зүгээс шийдвэрлэлээ. Ирж буй 2023 онд ГТЗ-ийн нийт гишүүд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-ний хэрэгжилтийг улам эрчимжүүлж, ёс зүйтэй, хариуцлагатай ажиллаж бидний хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр шим цаашид илүү олон хүнд хүрэх болно гэдэгт итгэлтэй байна. Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг бид хамтдаа бүтээнэ.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

БҮЛЭГ.1 ЗАСАГЛАЛ

1.1 ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА

Гурван талт зөвлөлийн дүрэмд зааснаар Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Түүнчлэн Зөвлөлийн тэргүүнээр талуудыг ахалж буй гишүүд жил бүрээр ээлжлэн ажиллах дүрмийн зохицуулалттай. Энэ дагуу 2022 оны 6 дугаар сараас эхлэн “Оюутолгой” ХХК-ийн талын ахлагч, Орон нутгийн харилцааны хэлтсийн менежер С.Дорждэрэм зөвлөлийн даргаар ажиллаж байна. ГТЗ-ийн Удирдах нэгжийн бүрэлдэхүүнд Орон нутгийн Засаг захиргааны төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Засаг даргын орлогч Х.Отгонжаргал, Малчдын төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл Ч.Намнансүрэн нар тус тус ажиллаж байна.

1.2 ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Орон нутгийн Засаг захиргааны төлөөлөл

(Х.Отгонжаргал) Ханбогд сумын Засаг даргын орлогч
(Б.Алтангэрэл) Ханбогд сумын ЗДТГ-ын Уул уурхай, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн
(Э.Жамбалсанжид) Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга
(М.Мягмаржав) Ханбогд сумын Баян багийн Засаг дарга
(Т.Насанбуян) Ханбогд сумын Гавилууд багийн Засаг дарга

Малчдын төлөөлөл

(Ч.Намнансүрэн) Жавхлант баг
(Б.Эрдэнэбаяр) Жавхлант багийн малчдын төлөөлөл
(Э.Сүрэнхорол) Жавхлант багийн малчдын төлөөлөл
(М.Батхүү) Баян багийн малчдын төлөөлөл
(Н.Одгэрэл) Баян багийн малчдын төлөөлөл
(Х.Энхбат) Баян багийн малчдын төлөөлөл
(Ц.Олонбаяр) Номгон багийн малчдын төлөөлөл
(Ч.Сувдаа) Номгон багийн малчдын төлөөлөл
(У.Гантөмөр) Номгон багийн малчдын төлөөлөл
(Б.Баярцэнгэл) Гавилууд багийн малчдын төлөөлөл
(Д.Эрдэнэцэцэг) Гавилууд багийн малчдын төлөөлөл
(Ц.Баттогтох) Гавилууд багийн малчдын төлөөлөл

“Оюутолгой” ХХК-ийн төлөөлөл

(С.Дорждэрэм) Орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг, түншлэлийн менежер
(П.Золбуянхишиг) Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн
(Л.Мөнх-Оргил) Уурхайн үйл ажиллагаа хариуцсан ерөнхий зөвлөх
(Б.Ууганбаяр) Байгаль орчны хэлтсийн менежер
(Ж.Эрдэнэбилэг) Хөдөлмөрийн харилцааны хэлтсийн менежер

1.3 ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУРАЛ, СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ, АЖЛЫН ХЭСЭГ

Гурван талт зөвлөлийн хурал

Гурван талт зөвлөлийн дүрэмд заасны дагуу Зөвлөлийн хурлыг тогтмол зохион байгуулав. Тайлант онд Гурван талт зөвлөлийн хурлыг бүх гишүүдийн оролцоотойгоор 1, 6, 9, 11, 12

дугаар сард нийт 5 удаа зохион байгуулсан. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас оны эхний 4 сард багийн Иргэдийн нийтийн хурал зохион байгуулагдаагүй. Үүнээс шалтгаалан тайлант оны эхний хагас жилд ГТЗ-ийн хурлыг тогтмол зохион байгуулах боломжгүй болсон. Багийн ИНХ хуралдсаны дараа буюу 2022 оны 5 дугаар сараас Гурван талт зөвлөлийн шинэ бүрэлдэхүүн албажин, үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Удирдах нэгжийн хурал, Малчдын төлөөллийн уулзалт

2022 онд Гурван талт зөвлөлийн Удирдах нэгж нийт 9 удаагийн хамтын уулзалт, хурал хийв. Эдгээр хурал, уулзалтаар цаг үеийн асуудлыг хэлэлцэхээс гадна хэрэгжилт удааширч буй төсөл арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх, ГТЗ-ийн ээлжит хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцэх асуудал, хөтөлбөр бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Малчдын төлөөлөл 6 удаагийн уулзалт хийж, ГТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудал болон малчдад тулгамдаж буй асуудлаар ярилцав.

Ажлын хэсгүүд, бүтэц, чиг үүрэг

2022 онд ГТЗ-ийн зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр болон малчдын гомдол барагдуулах гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор дараах Ажлын хэсгүүдийг байгуулав.

- Хаягдал хадгалах байгууламжийн шүүрлийн асуудал хариуцсан ажлын хэсэг,
- Оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөрийн асуудал хариуцсан ажлын хэсэг,
- Оюутолгой-Дэлийн бууц хүртэлх автозамын асуудал хариуцсан ажлын хэсэг,
- Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлын хэсэг,
- Дундын хоршооны зохион байгуулалтын асуудал хариуцсан ажлын хэсэг,
- Малын тэжээлийн ургамал тариалах төсөл судлах ажлын хэсэг

 АЖЛЫН ХЭСГҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ Тухайлсан чиг үүрэг бүхий 6 ажлын хэсэг байгуулагдав					
Хаягдал хадгалах байгууламжийн шүүрлийн асуудал хариуцсан ажлын хэсэг	Оюутны сургалтын төлбөрийн тэтгэлэгт хөтөлбөрийн асуудал хариуцсан ажлын хэсэг	Оюутолгой-Дэлийн бууц хүртэлх автозамын асуудал хариуцсан ажлын хэсэг	Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлын хэсэг	Дундын хоршооны зохион байгуулалтын асуудал хариуцсан ажлын хэсэг	Малын тэжээлийн ургамал тариалах төсөл судлах ажлын хэсэг
- Ажлын хэсгийн ахлагч: (Б.Алтангэрэл) - ОНЗЗ: (Э.Жамбалсанжид) "Оюутолгой" компани: (С.Дорждарэм), (Б.Ууганбаяр), - Малчдын төлөөлөл: (Б.Эрдэнэбаяр)	- Э.Жамбалсанжид (Жавхлант баг) - М.Мягмаржав (Баян баг) - Ж.Эрдэнэбилэг ("Оюутолгой" компани) - Б.Ууганбаяр ("Оюутолгой" компани) - Ц.Баттогтох (Гавилууд багийн Малчдын төлөөлөл) - Х.Энхбат (Баян багийн Малчдын төлөөлөл) - Н.Одгэрэл (Баян багийн Малчдын төлөөлөл)	- Э.Жамбалсанжид – Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга - Д.Батаа – "Оюутолгой" компанийн төлөөлөл - Э.Сүрэнхорол – Жавхлант багийн Малчдын төлөөлөл	- Т.Насанбуян (Гавилууд баг) - Б.Баярбаатар ("Оюутолгой" компани) - Э.Жамбалсанжид – (Жавхлант баг) - М.Мягмаржав (Баян баг) - У.Гантөмөр (Номгон баг)	- Э.Жамбалсанжид (Жавхлант багийн Засаг дарга) - М.Мягмаржав (Баян багийн Засаг дарга) - У.Гантөмөр (Номгон багийн Засаг дарга) - Т.Насанбуян (Гавилууд багийн Засаг дарга) - Анхан шатны 4 хоршооны дарга, тэргүүлэгчид - ГТЗ-ийн Малчдын төлөөлөл	- Ажлын хэсгийн ахлагч: (Ч.Намнансүрэн) - Гишүүд: (Ц.Баттогтох), (М.Батхүү), (Б.Баярбаатар), (С.Дорждарэм), (Б.Алтангэрэл), (Т.Насанбуян)

Улаанбаатар хотод туршлага судлав

Гурван талт зөвлөлийнхний туршлага судлах арга хэмжээг 2022 оны нэгдүгээр сарын 11-14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох шат дамжлагуудтай танилцах, бэлчээрийн зүй

зохистой ашиглалт, малын тэжээлийн ургамлын тариалалт зэрэг сэдвийн хүрээнд зөвлөлийн гишүүд туршлага судалж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцав.

“Рио Тинто” компанийн Гүйцэтгэх захирал Якоб Стаусхольмтой уулзав

“Рио Тинто” компанийн Гүйцэтгэх захирал Якоб Стаусхольм 2022 оны долоодугаар сард Оюутолгойн уурхайгаар зочилж, Ханбогд суманд айлчилсан билээ. Тэрээр долоодугаар сарын 14-ний өдөр Гурван талт зөвлөлийн хуучин болон шинэ гишүүдийн төлөөллийг Ханбогд сумын Иргэдийн хөгжлийн төвд хүлээн авч уулзсан юм. Уулзалтын үеэр ГТЗ-ийн үйл ажиллагаа, “Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2”-т тусгагдсан ажлуудын хэрэгжилт болон цаашид “Оюутолгой” ХХК-ийн бүтээн байгуулалт, олборлолттой холбоотой анхаарах шаардлагатай асуудлаар ГТЗ-ийн гишүүдийн санал бодлыг сонсож, цаашдын ажилдаа хэрэгжүүлж ажиллахаар ярилцав.

Чадавхжуулах сургалтад хамрагдав

ГТЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалт 2022 оны есдүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотноо зохиогдов. Сургалтыг тус зөвлөлийн Нарийн бичгийн газраас зохион байгуулсан юм. “Хувь хүний манлайлал”, “Талуудын хамтын ажиллагаа”, “Тэгш оролцоог хангахын ач холбогдол, зарчим” зэрэг сэдвээр “Бидний оролцоо нөлөөлөл” ТББ-ын тэргүүн, Үндэсний сургагч багш Ж.Чанцалдулам, ADRA Mongolia Органик ХАА-н түншлэл төслийн Бизнесийн зөвлөх, сургагч багш Б.Байгалмаа нар хичээл заав. Мөн ГТЗ-ийн эвлэрүүлэн зуучлагч, зөвлөхөөр ажиллаж байсан Б.Нандинчимэг сургалтад оролцож, Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн болон анхаарах асуудлуудаар санал бодлоо солилцлоо.



Гавилууд омгийн хонины баяр, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаанд оролцов, мэдээлэл хүргэв

2022 оны есдүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Ханбогд сумын төвд "Галбын говийн улаан тэмээ, гавилууд омгийн хонины генефондыг хамгаалж, бататган сайжруулах нь" сэдэвт малчдын зөвлөгөөн болов. Зөвлөгөөний үеэр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа зохиогдсон бөгөөд ГТЗ-ийн шийдвэрээр хараат бус Нарийн бичгийн байгууллага оролцож, ГТЗ-өөс 2022 онд хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаар иргэдэд мэдээлэл хүргэж, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудыг танилцуулав.



1.4 ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ

ГТЗ-ийн дүрмийн 7 дугаар бүлэгт зааснаар тус зөвлөлийн Малчдын төлөөллийн зөвлөхөөр Хариуцлагатай байдлын зөвлөл (Accountability Council International NGO-AC) олон улсын байгууллага, ГТЗ-ийн Малчны зах, мал нядалгааны замыг байгуулах төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, Малчин аппликейшн, Тогтвортой хөгжлийн төслүүдийн зөвлөхөөр "Хөгжлийн шийдэл" ТББ тус тус ажиллаж байна. Тайлант хугацаанд ГТЗ-ийн дотоод хяналт үнэлгээ, Малчдын төлөөллийн зөвлөлийн хяналт үнэлгээг хийж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллав. ГТЗ-ийн дотоод хяналт үнэлгээг 2022 оны 12 дугаар сард ГТЗ-ийн ээлжит хурлаар хэлэлцэн зохион байгууллаа.

Өрхийн хөөн хэлэлцэх нөхөн олговор олгох ажил хамгийн өндөр гүйцэтгэлтэй буюу 95.1% байна. Харин нийтийн нөхөн олговрын хүрээнд тохирсон ажлын хэрэгжилт хамгийн доогуур буюу 41%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт 1-д гэрээний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлээ.

ГТЗ-ийн засаглалын хэрэгжилт, зөвлөлийн үйл ажиллагаа, Малчдын гомдол барагдуулах 2 гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн байгууллагаар хараат бус үнэлгээ хийлгэхээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зарлаад байна.

1.5 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ГТЗ-ийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг ГТЗ-ийн <http://tpc.mn/> цахим хуудас, зөвлөлийн албан ёсны (<https://www.facebook.com/TripartiteCouncilB>) фейсбүүк пэйж хуудсаар тогтмол хүргэж байна. Мөн ГТЗ-ийн албан ёсны и-мэйл (tripartitecouncil.kb@gmail.com) хаягийг ГТЗ-ийн нарийн бичгийн ажилтан хариуцан ажиллаж байна.




Түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2022 оны есдүгээр сард Ханбогд сумын 4 багийн малчдыг төлөөлсөн гишүүдээр дамжуулан ГТЗ-өөс хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээ болон цаг үеийн мэдээллийг хэвлэмэл тайлан хэлбэрээр бэлтгэн, малчин өрх, сонирхогч талуудад хүргүүлэв.

1.9 САНАЛ ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2022 онд ГТЗ-д хандан, орон нутгийн 3 иргэнээс хүсэлт ирүүлснийг ээлжит хурлаар хэлэлцэж, хариуг нь хүргүүлэв.

БҮЛЭГ.2 ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТУСГАГДСАН 64 АЖЛЫГ ХАРУУЛБАЛ

дэд сэдвийн хүрээнд нийт 64 асуудлыг шийдвэрлэхээр тусгасан юм. 2022 онд гэрээний хэрэгжилтийг үнэлж үзэхэд (Малчдын гомдол барагдуулах гэрээ-1, гэрээ-2)-нд тусгагдсан нийт 64 ажлаас 26 ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. Бүрэн хэрэгжсэн ажлуудаас ач холбогдол, үр ашгийг нь харгалзан үзсэний үндсэн дээр зарим ажлыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад байна.

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн талууд болох Ханбогд сумын Засаг захиргаа, Ханбогд сумын малчид, “Оюутолгой” компани хамтран 2017 оны 5 дугаар сарын 9-нд Малчдын гомдол барагдуулах хоёр багц гэрээг байгуулсан билээ. Энэхүү хоёр гэрээнд Бэлчээр, Ус, Нөхөн олговор, Ундай гол зэрэг

2.1 ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ НӨХӨН ОЛГОВОР



Гурван талт зөвлөл нь Гэрээнд тохирсон ажлыг хэрэгжүүлэхийн тулд 2004, 2011 оны нөхөн олговрын хөтөлбөртэй холбоотой малчдын нэхэмжлэлийг шийдвэрлэх үүрэг бүхий Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны (Нэхэмжлэлийн хороо) үүргийг 2017 оны 6 дугаар сараас 2019 оны

3 дугаар сар хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн. Нэхэмжлэлийн хороо нь нийт 235 нэхэмжлэх хүлээн авсан бөгөөд 160 өрхийн нэхэмжлэх нь шалгуур хангасан тул нөхөн олговор олгосон байна.

2.2 2022 онд зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

2.2.1 “Эрүүл малчин-3” хөтөлбөр


Энэхүү хөтөлбөрийг ГТЗ санаачилсан бөгөөд Ханбогд сумын малчид, алслагдсан бүс нутаг, отрын айл өрхүүдэд эрүүл мэндийн зөөврийн тусламж үйлчилгээг сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, олон улсын стандартад нийцүүлэн чанартай, хүртээмжтэй хүргэх, оношилгоо шинжилгээ хийх зорилготой. “Эрүүл малчин-3” төсөл нь гурван үе шаттай.




2022 оны тавдугаар сараас эхлэн Сумын Эрүүл мэндийн төвөөс хөдөөгийн багуудаар үзлэгийн 2 баг үе шаттайгаар явуулж, иргэдийг үзлэгт хамруулав. Үзлэгийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор үзлэгт хамрагдаагүй үлдсэн иргэд, малчдад үзлэгийн талаарх мэдээлэл болон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн ач тусын талаарх мэдээллийг 4 багийн өдөрлөгийн үеэр өгч ажиллав.

2022 онд үзлэгт хамрагдсан хувьд орон нутагт 96,4%, Улаанбаатар хотод 82,2%-тай байна.

Бриллиант эмнэлэгийн үзлэг шинжилгээнд хамрагалт
Хувиар /Нийт орхийн дунд эзлэх/




Хамрагдсан хүний тоо



2.2.2 Усжуулалт

Ханбогд сумын “Гурван талт зөвлөл”-ийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд эвдэрч муудсан худгуудыг сэргээн завсарлах, бүрэн тоноглогдсон сувагчилтай худаг шинээр гаргах, малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж байна. Засварлах болон шинээр гаргах, нарны панел суурилуулах худгийг сонгохдоо



Ханбогд сумын багийн иргэдийн нийтийн хурал, Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн сонгож байгаа. Ажлын гүйцэтгэлийг Сумын Засаг даргын тамгын газраас томилогдсон ажлын хэсэг хянаж хүлээн авдаг. Ингэхдээ худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт

саналыг нь тусган ажиллаж байна.

Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил

Гурван талт зөвлөлийн шийдвэрээр хэрэгжиж буй төслүүдийн нэг нь бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил” юм.

Энэхүү ажлыг “Женерал Лайтс” ХХК гүйцэтгэсэн бөгөөд Ханбогд сумын 4 багийн нутаг дэвсгэрт нийт 22 гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулав. Уг ажлыг 2023 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгаад байна.

“Малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажил”

“Женерал лайтс”
ХХК Ханбогд
сумын 4 багийн
нутаг дэвсгэрт
нийт 22 худагт
суурилуулан
2022.09.10-ны
өдөр хүлээлгэн
өгсөн.



Малчдын гар худаг сэргээн засварлах ажил

Ханбогд сумын “Гурван талт зөвлөл”-ийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд хуучин эвдэрч муудсан худгууд болон зун намрын отрын бүсийг усжуулах зорилгоор малчдын гар худгийг сэргээн засварлах ажлыг 2019 оноос хийж гүйцэтгэж байна. Засварлах худгийг сонгохдоо Ханбогд сумын багуудын иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж, баг тус бүрээс 5 гар худаг, жилдээ нийт 20 гар худгийг засварлаж байна. 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл нийт 76 гар худгийг засварлаад байна. Гар худаг засварын ажлыг гүйцэтгүүлэхээр “Оюутолгой” компаниас орон нутагт тендер зарласан бөгөөд гүйцэтгэгчээр “Ботгон хөөвөр”, “Хан жавхлант” зэрэг орон нутгийн компани шалгарч, ажлыг гүйцэтгэж байна. Ханбогд сумын Засаг даргын тамгын газраас томилогдсон ажлын хэсэг худгуудыг хүлээж авахдаа худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт тэдний саналыг тусгаж ажиллав.

Бүрэн тоноглогдсон сувагчилтай худгийн ажил



2.2.3 Малчдын хороо бууц засварын ажил

ГТЗ-ийн 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар малчдын санал хүсэлтэд тулгуурлан Ханбогд сумын “Малчдын хороо бууцыг засварлах ажил”-ыг гүйцэтгэхээр тохиролцсон. Энэхүү ажлын гүйцэтгэгчээр орон нутгийн “Батсэтгэл” ХХК шалгарч, Орон нутгийн засаг захиргаа, “Оюутолгой” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллав. Тус компани малчдын 257 хороо, бууцыг засварлав.



2.2.4 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр

Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №1 Хавсралт 1-ийн 4.10.2

Хэрэгжүүлэгч: Гурван талт зөвлөл, “Ханбогд хөгжлийн хэлхээ” ТББ

Хамрагдсан оюутны тоо: 22

Оюутны тэтгэлгийн нийт олгогдсон мөнгөн дүн: 193,0 сая төгрөг

Төсөл хэрэгжсэн газар: Өмнөговь аймаг Ханбогд сум

Төсөл хэрэгжсэн хугацаа: 2019 оны 06 дугаар сар-2022 он



Гурван талт зөвлөл нь гэрээнд тохирсон ажлын хүрээнд Ханбогд сумын малчин өрхүүдэд хүртээмжтэй байдлаар нийтийн нөхөн олговор олгох үүднээс 2017 онд дотоодын их дээд

сургуульд элсэн суралцаж буй малчин өрхийн оюутнуудад дараах шалгуурын дагуу сургалтын тэтгэлэг олгох нэг удаагийн ажил хэрэгжүүлсэн.

- Ханбогд сумын малчин өрхийн оюутан байх
- Дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуульд суралцдаг байх
- Голч оноо нь 2.7-оос дээш;
- Өөр төрлийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй байх
- Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлийн мэргэжлээр суралцаж буй малчдын оюутан хүүхдүүдэд олгох

2.2.5 Малчны зах, мал нядалгааны зам байгуулах төсөл

Төсөл амжилттай хэрэгжсэнээр Ханбогд суманд өдөрт 10 бод, 100 бог мал нядлах хүчин чадалтай, 100 тонн мах хадгалах хөргүүр бүхий үйлдвэр барьж ашиглалтад оруулах юм.

- Мал нядалгааны зам, малчны зах төслийн барилгын зураг төсвийг “Тоонто Гранд” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өгөв. Ханбогд сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгосон талбайд хөрс, геодезийн шинжилгээ, дэд бүтцийн тодруулга судалгааг “Хан Дизель” ОНӨААТҮГ-тай хамтран гүйцэтгээд байна.
- Барилгын зураг төслийг баталгаажуулахтай холбоотой Барилга, хот байгуулалтын яамны барилгын хөгжлийн төвийн магадлал, аймгийн Онцгой байдлын газрын дүгнэлт, Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт, шугам сүлжээний байгууллагуудаар баталгаажуулалтын ажил хийгдсэн.
- Мал нядалгааны зам төслийн байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг “Бурхан буудай” ХХК гүйцэтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ажлын хэсэгт танилцуулж, баталгаажуулсан.
- Байгаль орчны үнэлгээний дагуу хатуу хог хаягдлыг сумын хогийн цэгт тусгайлан хаях, шингэн хог хаягдлыг “Хан дизель” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан тухай бүр шийдвэрлэх боломжтой талаар урьдчилсан судалгаа хийсэн.
- Гүний худгийн цэг тогтоох ажилд Галба Өөш долоодын сав газраас зөвлөх инженер ажиллуулж, үйлдвэр баригдах газарт хийсэн усны судалгааны тайланг үндэслэн цэг тогтоож, ундаргыг хангалттай гэж үзэв.
- Мал нядалгааны зам, малчны зах төслийн зураг төсвийг стандарт шаардлагын дагуу мэргэжлийн байгууллагуудаар батлуулж, зургийн дагуу мал нядалгааны зам, малчны хүнсний зах, түүхий эдийн зах болох 3 барилгын бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлсэн. Үүнд;
 - Инженер, геологийн судалгаа
 - Барилга угсралтын төсөв (3 барилга)
 - Барилга угсралтын загвар зураг
 - Барилга угсралтын ажлын зураг
 - Барилга бүтцийн зураг
- Байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний хүрээнд үйлдвэрийн менежментийн төлөвлөгөөг жил бүр БОАЖЯ-аар батлуулж, хэрэгжилтийг сумын ИТХ болон орон нутгийн иргэдэд тайлагнахаар шийдвэрлэсэн.

2.2 Тогтвортой амьжиргааны төсөл хөтөлбөр

“Оюутолгой” компани 2011 онд Нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан 89 өрхтэй байгуулсан 5 жилийн гэрээний хугацаа дуусгавар болсон билээ. Тэдгээр өрхийн амьжиргааг тогтвортой болгох, хадгалах зорилготой “Амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөр”-ийг 2018 онд “Оюутолгой” компаниас санхүүжүүлэн 1 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрт нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдсан нийт 91 өрхийн 92 суралцагч нэг жилийн хугацаанд сургалтад хамрагдан, тэтгэлэг хүртсэн бөгөөд цаашид амьжиргааа тогтвортой авч явах боломж бүрдүүлэхийг зорьсон. Хоршоодын үйл ажиллагааг сайжруулах, тогтворжуулах зорилгоор бизнесийн зөвлөхөөр “Хөгжлийн шийдэл” ТББ

ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

- **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТӨСӨЛ**

"Энергийн ундарга" хоршоо

- **ОЁДЛЫН ТӨСӨЛ**

Говь Хан Уран ХХК

- **АНГУС ҮХЭР ҮРЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

"Үнээгийн говь" хоршоо

- **ГАВИЛУУД ОМГИЙН ХОНИНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ТӨСӨЛ**

"Гавилууд шилмэл сүрэг" хоршоо

- **ГАХАЙН АЖ АХУЙ ЭРХЛЭХ ТӨСӨЛ**

Судалгааны шатандаа хэрэгжиж байгаа



ажиллаж байна. 2018–2023 он хүртэл 5 жилийн стратеги төлөвлөгөөгөө “Хөгжлийн шийдэл” бизнесийн зөвлөх байгууллагын тусламжтайгаар боловсруулж хэрэгжүүлсэн.

Газар тариалангийн төсөл (Энергийн ундарга хоршоо)

2019 онд 9 малчин өрх нэгдэж “Энергийн ундарга” хоршоог байгуулан, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байна.

“Энергийн ундарга” хоршооны гишүүд өргөст хэмх, улаан лооль зэрэг нарийн ногоог хоршооны 4 хүлэмжид, төмс хүнсний ногоог 2 га ил талбайд тариалж байгаа бо, хоршооны 1 гишүүн өвөлжөөнийхөө дэргэд тэжээлийн ургамал, эрдэнэшиш, төмс хүнсний ногоо тариалж байна.

Тариалсан ургацаа орон нутгийн дэлгүүр болон “Оюутолгой” компанид нийлүүлж, борлуулдаг. 2022 онд хоршооны хүсэлтээр “Оюутолгой” компаниас шаардлагатай 18.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг олгосон. Уг санхүүжилтээр 1 га талбайгаа нэмж хагалж усалгааны иж бүрэн систем суурилуулан, жилийн хугацаатай мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авсан байна. Мэргэжлийн зөвлөх авснаар Ханбогд суманд хүнсний ногооны аж ахуйг ил талбайн тариалалт болон хамгаалагдсан хөрсний аж ахуйг зэрэгцүүлэн хөгжүүлэх, ургамлын тариалалтын үе шатнаас эхлээд арчилгаа, хамгаалалт, ургац хураах хүртэлх бүхий л дамжлагын талаар мэдлэг мэдээлэлтэй болж байна.

Тариалсан ургацын мэдээлэл

Он	Ажилласан гишүүд	Ногооны нэр, төрөл	Ургац (тонн)	Тайлбар
----	------------------	--------------------	--------------	---------

2020	4	10	9380	-
2021	5	12	13369	-
2022	5	12	9.810	2022 оны 8 дугаар сард Ханбогд суманд орсон түр зуурын хүчтэй ширүүн борооны улмаас 1 га талбайн тарвасны ургац алдсан

Хүлэмж ил талбайн тариалалт



Оёдлын төсөл (“Говь хан уран” ХХК)

Оёдлын сургалтад хамрагдсан 12 малчин эмэгтэй орлогын нэмэлт эх үүсвэртэй болох хүсэл сонирхлоороо нэгдэж, өөрсдийн санаачилгаар 2017 онд “Говь хан уран” компанийг байгуулсан билээ. Тус компанид “Оюутолгой” компаниас санхүүжилт өгсөн байна. Мөн бизнес менежментийн зөвлөхүүд, ижил төстэй бизнес эрхлэгчид, “Оюутолгой” ХХК-ийн Хангамжийн хэлтэс ба бусад боломжит худалдан авагчидтай холбож өгснөөр оёдлын үйлдвэрийн үйл ажиллагаа тогтворжиж, дараах амжилтыг гаргаад байна.



- Ханбогд суман дахь Залуучууд хөгжлийн төвийн гарааны бизнесийн хөтөлбөрт хамрагдаж, гуравдугаар байрт шалгарснаар нэмэлт сургалт авах, үйл ажиллагаа эхлүүлэх боломжтой болов.
- 2018 онд “Оюутолгой” компанид хөдөлмөр хамгааллын хувцас болон баяжмалын дээжийн уут нийлүүлэх гэрээ зурснаар байнгын ажилтай болж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлсэн.
- 2019 онд Колумби улсад зохиогдсон дэлхийн 70 гаруй улсын залуу бизнес эрхлэгчдийн чуулганд оролцсон. Мөн үеэр оёдлын компанийн бизнесийн

хурдацтай өсөлт, амжилтаараа нэр дэвшин өрсөлдөж, олон улсын оны шилдэг залуу бизнес эрхлэгчээр шалгарсан.

2022 оны байдлаар тус компани 15 оёдолчин, 15 тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа явуулж, “Оюутолгой” ХХК-д коврол, туг, кабелийн ханцуйвч гэрээгээр нийлүүлж байна. 2019 оноос эхлэн компанийг үүсгэн байгуулсан хувьцаа эзэмшигч 12 эмэгтэйдээ жил бүр ногдол ашиг олгож байна.

Ангус үхэр үржүүлэх төсөл (“Үнээгийн говь хоршоо”)

“Үнээгийн говь” хоршоо нь 2018 онд байгуулагдсан, 12 гишүүнтэй, Ханбогд суманд үйл ажиллагаа явуулдаг махны чиглэлийн ангус үхэр үржүүлгийн аж ахуй юм.

2022 онд амьжиргаа дэмжих төслийн хүрээнд цэвэр цусны Ангус үүлдрийн, говийн нөхцөлд бэлчээрт амьдрах чадвартай үхэртэй болох, улмаар олон улсын стандарт шаардлагыг хангасан мах бэлтгэх зорилгоор “Оюутолгой” ХХК-иас нэмэлт санхүүжилт олгосон байна. Төслийн хүрээнд 2022 онд “Гацуурт” ХХК-иас цэвэр цусны 8 ангус бух худалдан авчээ.

“Үнээгийн говь” хоршоо нь байгуулагдсан үеэсээ эхлэн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, Ханбогд суманд мал угаалгын ванн барьж, нутгийн малчдын тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн байна. 2022 онд уг ваннаар нийт 7000 бог мал угаажээ. Мөн хоршооны хөрөнгөө “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн” программд бүртгүүлсэн Ханбогд сумын анхны хоршоо болсон. Тус хоршооны 12 малчин дундын сандаа жил бүр хуримтлал үүсгэдэг бөгөөд сангийн мөнгөөрөө өвс тэжээл үнэ хямд байх үед нь худалдан авалт хийж, өвөлжилтийн бэлтгэлээ хангадаг байна.

Махны чиглэлийн Гавилууд омгийн хонины аж ахуй эрхлэх төсөл (Гавилууд шилмэл сүрэг хоршоо)



“Гавилууд шилмэл сүрэг” хоршоог 2019 онд 13 өрх байгуулсан юм. Тус хоршоо “Оюутолгой” ХХК-ийн санхүүжилтээр нийт 455 хонийг худалдан авсан бол 2022 оны байдлаар хонины тоо толгой 779 хүрээд байна. 2022 онд хоршооны үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 26 хонь борлуулжээ. Түүнчлэн хоршооны дарга болон гишүүд ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй хоршоодоос туршлага

судлах 5 удаагийн сургалт, арга хэмжээнд хамрагдсан байна. Төслийн хүрээнд хонины арьс нэхий боловсруулах цехийн барилгыг барьж, тоног төхөөрөмж суурилуулаад байна.

Гавилууд омгийн хонины үүлдэр нь 2021 онд Гавилууд хэвшил омог болж батлагдсан юм. Гавилууд омгийн хонь дунджаар 5.3-7.8 хувийн илүү жинтэй. Энэхүү үзүүлэлтээрээ улсын хэмжээнд 4 дүгээрт орж байна.

2022 онд Амьжиргаа дэмжих төслийн хүрээнд Гахайн аж ахуй эрхлэх төсөл хэрэгжихээр болж, төлөвлөлтийн ажил хийгдэж байна. Амьжиргаа дэмжих төсөлд давхардсан тоогоор

нийт 69 малчин хамрагджээ. 2004 оны гэрээтэй 10 өрхийн 7 нь энэхүү амьжиргаа дэмжих төсөлд хамрагдаад байна.

Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт

Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөг 2018-2020 онд боловсруулсан бөгөөд өрх бүрийн онцлог, өрхийн гишүүдийн чадавх, амьжиргааны давуу тал зэрэгт тохируулан өрхийн гишүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлсэн юм. Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөө нь гурван жилийн хугацаанд амьжиргааг сэргээх бодит арга хэмжээ хэрэгжүүлэхээр цаг хугацааг нарийвчлан тодорхойлж ажилласан байна. Өрхийн амьжиргааны түвшинг сумын ядуурлын түвшинтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнөөр энэхүү төлөвлөгөөний үр дүнг хэмжих юм.

Энэхүү ажлын хүрээнд дараах чиглэлээр өрхүүдтэй хамтран ажиллаж, төлөвлөгдсөн санхүүжилтийг хуваарийн дагуу олгосон байна.

- Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилтээр ажлын байр барих, бэлэг дурсгалын дэлгүүр, үзмэрийн газар байгуулах, гар урлалын бүтээгдэхүүн хийх зэргээр 4 өрх бизнес эрхлэх, 7 өрх мал худалдан авч ашиг шимийг хүртэх зорилгоор төлөвлөгөө гарган “Оюутолгой” компанитай хамтран ажиллав.
- 2018 оноос хойш жил бүр 11 өрхөөс төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлан мэдээллийг тогтмол авсан бөгөөд өрхийн амьжиргаа 10-40 хувиар өссөн байна.
- Малчдын амьжиргааг дэмжих төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Хөгжлийн шийдэл” ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж, өрхийн гишүүдийн бизнес саналыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

ӨРХИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 оноос хойш жил бүр 11 өрхөөс төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн тайлан мэдээллийг тогтмол авсан.
Өрхийн амьжиргаа нь **10-40** хувиар өссөн.



өрх бизнес
эрхлэх төсөл



өрх мал худалдан авч
ашиг шимийг хүртэх
төсөл

2.4 “Ундайн голын өв соёл” төсөл

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настнуудад уламжлалт мал аж ахуйн мэдлэг сургаалаа залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд нь зориулж урамшуулал олгох зорилго бүхий төслийг 2019 оны 6 дугаар сараас Ханбогд сумын “Галба” ахмадын хороотой хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Төслийн хүрээнд 2019 онд Жавхлант багийн 38 ахмад давхардсан тоогоор 2236 хүүхэд залууст, 2021 онд 63 ахмад сар бүр 10-аас доошгүй хүүхэд залууст, 2021 онд давхардсан тоогоор 2728 хүнд сургалт явуулсан байна.

“Ундайн голын өв соёл” төслийн хүрээнд 2022 онд давхардсан тоогоор 4564 хүнд сургалт явуулжээ. Нийтдээ 4 жилийн хугацаанд давхардсан тоогоор 10,726 иргэнийг сургалтад хамруулаад байна.

2023 оны 1 дүгээр сараас Ханбогд сумын “Галба” ахмадын хороотой 3 жил хамтран ажиллах гэрээ байгуулаад байна. Ханбогд сумын 80-аас дээш насны ахмадууд уг төсөлд хамрагдаж, ахуй амьдралдаа хэрэгжүүлж ирсэн арга ухаан, эрдэнэт мал сүрэгтэйгээ холбогдох өв уламжлалаа ирээдүй хойч үеийн залуустаа өвлүүлэн үлдээх их үйлсэд гар бие оролцож байна.

Нас өндөр болсон ахмадууд маань гэртээ үр ач нартайгаа хөлөгт тоглоом болон шагайгаар төрөл бүрийн наадгай тоглож өнгөрүүлдэг нь нэг талаараа сургалт болж, хүүхэд залууст уламжлалт тоглоом наадгайгаар тоглоход сургаж байгаа юм.

№	Огноо	Үргэлжилсэн сар	Ахмадын тоо (давхардсан)	Сургалтад хамрагдсан хүний тоо
1	2019	6-12	38 ахмад	2236 хүн
2	2020	10-12	54 ахмад	1198 хүн
3	2021	1-10	55 ахмад	2728 хүн
4	2022	1-12	69 ахмад	4564 хүн
НИЙТ ДҮН		29 сар	216 ахмад	10,726 хүн

2.5 МОНИТОРИНГ

“Оюутолгой” ХХК-ийн Орон нутгийн харилцааны хэлтэс, Байгаль орчны хэлтсүүд хамтран 2011 оноос нутгийн малчдын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Гурван талт зөвлөлийн шийдвэрийн дагуу уг хөтөлбөрийг “Мөнх ногоон Галба” ТББ өнөөг хүртэл амжилттай гүйцэтгэж байна.

Мониторингийн төрлүүд

- ✓ Усны хяналт, шинжилгээ: Малчдын гар худаг болон гүний худаг, байгалийн задгай уст цэг, Ханбогд сумын ус хангамжийн цооног, усны чанар, хаягдлын сан
- ✓ Зэрлэг амьтан, шувууд: Нүүдэл, шилжилт хөдөлгөөн
- ✓ Бэлчээрийн ургамлын судалгаа: Ургамлын бүрхэвч түүний төрөл, тархац, био масс
- ✓ Агаарын чанар: Уурхайн үйл ажиллагаа, зам ашиглалтаас үүсэх тоосжилт
- ✓ Ховор мод: Тоорой, хайлаас модны тооллого

Усны хяналт, шинжилгээ

Малчдын гүн өрмийн болон инженерийн хийцтэй худаг

Ханбогд сумын 4 багийг хамарсан нийт 16 гүн өрмийн болон инженерийн хийцтэй худаг, ирээдүйд ашиглах усан хангамжийн 18 цооногуудад улиралд нэг удаагийн давтамжтай хэмжилт хийгдэж байна. Хэмжилт хийхдээ гар ажиллагаатай автомат түвшин хэмжигч багаж ашиглаж байгаа ба эдгээр худгуудад цаг агаар болон улирлын чанартай

усны түвшин хэлбэлзэл ажиглагдаж байна. Худгуудын дундаж түвшний хэлбэлзэл 0.5см-1м байгаа нь хэмжилт хийгдэхээс өмнө мал уусан эсвэл хэмжилтийн алдаа гарсан байж болзошгүй.

Инженерийн хийцтэй гүний худгийн хэмжилт сар бүр тогтмол хийгдэж байгаа бөгөөд худгуудын хэлбэлзэл харьцангуй тогтвортой байна. Нийт багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 8 булаг задгайд 2021 оноос эхлэн задгай уст цэгийн хэмжилт хийж эхэлсэн. Эдгээр булаг задгайн нь тэжээмжийн мужид буух хур тунадасны хэмжээнээс хамаарч усны хэмжээ нэмэгдэж буурч байна.

Усны чанар


Ханбогд сумын төв болон иргэд малчдын ашигладаг унд ахуйн усны чанар өөрчлөгдөхөөс сэргийлэх, өөрчлөгдсөн тохиолдолд хурдан шуурхай арга хэмжээ авахад туслах мэдээллийн бааз бий болгох зорилгоор 10 цэгт усны чанарын мониторингийг жил бүр хийж байна. Усны дээжийг сумын төвийн хүн ам олноор ашигладаг болон малчдын энгийн гар худаг, Оюутолгой төслийн талбайн “Хаягдлын сан” орчмын худгуудаас түүвэрлэн дээж авч Улаанбаатар хотын магадлан итгэмжлэгдсэн “Ханлаб” лабораторид шинжлүүлэн усны химийн болон бактерлогийн хяналт хийхэд стандартын шаардлага хангаж байна. Дээжний хариуг холбогдох байгууллага болон иргэд малчдад хүргэж байна. Дээжийг төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс ус ашиглагч хэрэглэгч хүртэлх ус хангамжийн үе шат бүрд хүн амын ундны болон ахуйн зориулалтаар хэрэглэх усны эрүүл ахуйн шаардлага аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх MNS 9000:2018 дагуу шинжлүүлсэн.

Оюу толгой ХХК нь 69 энгийн гар худагт хэмжилт хийдэг бол “Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллагын хяналт шинжилгээ нь 87 энгийн гар худаг дээр хийгддэг. Нийт 156 гар худгаас хоёр байгууллагын хэмжилтэд 15 худаг давхцаж хамрагддаг бөгөөд байгууллагуудын хэмжилтийн зөрүү 8-20 см байна.



Зэрлэг амьтны ажиглалт судалгаа

“Мөнх ногоон галба” ТББ нь хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн хүрээнд тууртан амьтдын судалгааг 2022 онд 17 малчин өрхтэй хамтран сар бүрийн 20-ний өдөр тогтсон маршрутын дагуу хийж, тууртан амьтдыг бүртгэн, ажиглалт судалгааг хийж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар өвлийн улирал мотоциклийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотойгоор 2022 оны 01-03 сарын хугацаанд хээрийн ажиглалтыг түр зогсоосон.



Зураг 58 Зэрлэг амьтад ажиглалтын маршрут

№	Овог	Нэр	Баг	Гүйцэтгэл (Хувь)
1	Лантуу	Отгондүү	Номгон	33.3
2	Мөнхтоогоо	Ганганжав		100
3	Цэндоо	Чойжилсүрэн		100
4	Думаа	Батхуяг		11.1
5	Сэргэлэн	Анарбаяр		44.4
6	Чагдаг	Цэвэгдэлгэр	Гавилууд	11.1
7	Пүрэв	Баянмөнх		66.6
8	Цэцгээ	Баатарчулуун		77
9	Цэдэнноров	Амартүвшин		100
10	Болоож	Одхүү	Жавхлант	100
11	Мядаг	Содхүү		100
12	Алтанбагана	Жамъяандорж		88.8

13	Гонгожав	Дүнжгэр	Баян	100
14	Данзаншадав	Хишигбат		88.8
15	Аюуш	Баянмөнх		100
16	Лувсандаш	Батболд		100
17	Хургаа	Энхбат		33.3

Хулан адуу /Equus hemionus/




Хулан адуу Төв Азийн ихэнх хэсэгт XIII зуунд амьдарч байсан хэдий ч одоо дэлхий даяар нэн ховордож зөвхөн Монголын популяци нь харьцангуй тоо толгой ихтэй үлджээ. Дэлхийн хулан адууны популяцийн тоо толгойн 80% нь Монголын говь цөлд байна гэж судлаачид (Reading нар, 2001; Feh et al., 2002) үздэг байна. Хулан адууг агнах, устгахыг 1953 оноос хуулиар хориглож дархан цаазтай болгожээ. Хулан адуу нь

“Монгол улсын улаан ном” (1997), Монгол улсын ховор амьтны жагсаалт (1995), CITES-ийн I, CMS (Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенци)-ийн II хавсралд (2002) тус тус бүртгэгдсэн нэн ховор амьтан. Тархцийн хоёр цөм нутаг Говийн Бага дархан газар, Загийн ус зэргийг 1999 онд улсын тусгай хамгаалалтад авсан.

Ханбогд сумын хэмжээнд малчдын ажигласан хулан адууны тоог нэгтгэхэд 2022 оны 03-12-р сарын хугацаанд давхацсан тоогоор нийт 3570 хулан адуу тоологдсон байна.

Хар сүүлтий /Gazella subgutturosa/



Хар сүүлтий нь нэлээд уудам тархацтай боловч нягтшил бага. Алтайн өвөр Булган голоос зүүн тийш, Алтайн ар говьд Увс нуураас зүүн тийш, Их нууруудын хотгор, нуурын хөндийг дагаж, Өмнийн говь, Дорнын говь, Зүүн зах нь Сүхбаатар аймгийн нутаг хүртэл тархсан Монгол Улсын Улаан номд орсон, 1953 онд агнахыг хориглосон дархан цаазат ховор амьтан. Монгол орны хар сүүлтийн тархац, популяцийн хэмжээ буурч байгаа нь хяналт муу,

хууль бус агналт, орчны доройтол бэлчээр нутгийн өрсөлдөөн зэрэг хүчин зүйлтэй холбоотой.

Ханбогд сумын хэмжээнд малчдын ажигласан хар сүүлтийн тоог нэгтгэхэд 2022 оны 03-12-р сарын хугацаанд давхацсан тоогоор нийт 1093 Хар сүүлтий тоологдсон байна.

Аргаль хонь /Ovis ammon/



БНМАУ-ын АИХ-ын тогтоолоор 1953 онд аргаль хонь агнахыг хориглосон байна. Монгол улсын Засгийн газрын 1995 оны 152 дугаар тогтоолоор улсын нутаг дэвсгэрт аргаль хонь ховор амьтан мөн болохыг тодорхойлжээ. Монгол улсын Аргаль хонины тоо толгой сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч байгаа. Аргаль хонь нь “Зэрлэг амьтан ургамлын ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн” II (CITES) хавсралтанд бүртгэгдэж, Монгол улсын “Улаан номд бүртгэгдсэн байна. Монгол оронд аргаль

хонь нь Алтай хангайн уулархаг нутаг, Говь-Алтай зүүн гарын болон Алтайн өвөр говь Өмнөговь зэрэг нутгуудаар тархана.

Ханбогд сумын хэмжээнд малчдын ажигласан Аргаль хонины тоог нэгтгэхэд 2022 оны 03-12-р сарын хугацаанд давхацсан тоогоор нийт 72 Аргаль хонь тоологдсон байна.

Янгир ямаа / Capra sibirica /

Монгол Алтай, Говь Алтай, Зүүн гар, Алтайн өвөр говиудын уулс, Хан хөхий, Хорьдол сарьдаг, Улаан тайгын нуруу, Дундговь, Дорноговь аймгийн цөлөрхөг хээрийн бүсийн зарим уулсаар алаг цоог тархана. Бэсрэг уулсын бэл энгэр, аараг толгод, өндөр уулын эгц цавчим хад цохио, нуранги асга бүхий давчхан хавцал, ой модгүй, бартаа саадгүй газарт байршин нутаглана. Мах идэшт том шувууд хөхтний идэш тэжээл болно. Тэжээл усаар талтай давхцдаг ч онцгой сөрөг нөлөөгүй. Хөвсгөл орчим Хорьдол сарьдаг Улаан тайгын нуруунд 1000 гаруй, улсын хэмжээгээр 80 орчим мянган толгой тоологдсон байна.

Ханбогд сумын хэмжээнд малчдын ажигласан янгир ямааны тоог нэгтгэхэд 2022 оны 03 дугаар сараас 12 дугаар сарын хугацаанд давтагдсан тоогоор нийт 34 тоологдсон байна

“Мөнх ногоон галба” ТББ-ийн хийсэн хамтын оролцоотой хяналт-шинжилгээний ажлын хүрээнд 2022 оны зэрлэг амьтны судалгаагаар Ханбогд суманд хулан адуу 3570, хар сүүлт 1093, аргал хонь 72, янгир ямаа 34, нийт 4769 зэрлэг амьтдыг ажиглаж бүртгэсэн байна.



Мониторингийн үр дүнгээс үзэхэд 2022 оны 3, 5, 7, 8, 11, 12-р саруудад зэрлэг амьтны тоо толгой эрс буурсан байв. Энэ нь цаг уурын нөхцөлөөс гадна төмөр замын гарц гарамын тоо цөөн, гармуудын зай хэт хол зэрэг нь нөлөөлсөн байх магадлалтай юм. Тайлант онд сумын хэмжээнд олон жилийн дунджаас бага хур тунадас буусан бөгөөд ургамлын гарц бага байлаа.

Биотехникийн арга хэмжээ

Ханбогд сум цаашлаад говийн бүс нутагт хур бороо бага орж бэлчээрийн гарц муугаас улбаалж өвөлжилт хүндэрч зэрлэг амьтдад өвс тэжээл, усаар гачигдах эрсдэл үүсч байгаа тул тэдгээрийн амьдрах орчин болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага гарсан. “Мөнх ногоон галба” ТББ, Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, “Бодь интернэшнл” ХХК, Малчдын оролцоотой дараах 3 цэгт өвс тавих, татаал ухах ус гаргах ажлыг хийсэн.



1. Номгон багийн нутаг Далайн булаг
2. Номгон багийн нутаг Холхийн улаан-Овоо
3. Баян багийн нутаг Дунд хүрээ

Бэлчээрийн ургамлын судалгаа

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь говь цөлийн эмзэг хөрстэй бэлчээр нутагтайн дээр Оюу толгой ХХК болон том, жижиг олон орд газар байрладгаас шалтгаалан бэлчээрийн төлөв байдалд өөрчлөлт орж доройтолд өртвөл эргэж сэргээхэд хүндрэл учрах тул түүнээс сэргийлэх үүднээс бэлчээрийн даац, чадавхийн судалгааг хийж, зураглал гаргах болон бэлчээрт зонхилох зарим ховор ургамлын судалгааг хийх нь бэлчээр ашиглалтыг даац багтаамжид тохируулах менежмент боловсруулахад чухал суурь материал болох юм. “Мөнх ногоон Галба” ТББ, Ханбогд сумын ЗДТГ, Цаг уурын өртөө, “Оюу Толгой ХХК”-ийн Байгаль орчны хэлтэстэй хамтарсан судалгааны баг нь Ханбогд сумын нутаг дэвсгэрт урт хугацааны туршилт хийх, хяналт тавих зорилгоор бэлчээрийн хяналт, шинжилгээний 18 цэгийг байгуулсан.

№	Хяналт, шинжилгээний цэгийн бичиглэл	Уртраг	Өргөрөг
1	Билгэх	43.37989	107.71964

“Мөнх ногоон галба” ТББ нь бэлчээрийн хяналт-шинжилгээг малчдын оролцоотой 2020 оноос хойш хийсэн бөгөөд 2022 оны бэлчээрийн судалгааг 08 дугаар сарын 11-17-ний өдрүүдэд 8 малчинтай хамтран 18 цэгт шугам-цэгийн бичиглэл, олон наст ургамлын суурь хоорондын хоосон зайг хэмжих, ургацын дээж авах зэрэг арга зүйг ашиглан гүйцэтгэсэн байна. Ургамал газар зүйн мужлалын хувьд Ханбогд сумын нутгийн баруун хойд хэсэг нь Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт үлдсэн ихэнх хэсэг нь Алашаа говийн цөлийн тойрогт хамаарагдана. Ханбогд сумын ургамлын аймагт 2016 онд бид 30 овог, 89 төрөл, 123 зүйл бүртгэсэн нь цөл судлаач Санжидын бүртгэсэн 242 зүйл ургамлын 50.8% болж байна. Бэлчээрийн судалгааны талбайд нийт 13 овог, 33 төрөл, 50 зүйл ургамал бүртгэсэн. Дээрх бүлгэмдлүүдэд 10м2 талбайдаа 9-21 зүйлтэй, 1м2 талбайд 3-6 зүйл ургамалтай, Баглуур, Монгол өвс, шар мод, хотир, таана, бударгана, тэсэг зонхилсон, доройтсон бэлчээртээ Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), Ktze.), бусад хөл газрын ургамал түрж ургасан, 20.0-36.0% тусгаг бүрхэцтэй, ургац 2022 онд 0.6-4.2 ц/га болсон байна. Жил ирэх тусам ургамлын зүйлийн тоо нэмэгдэж байгаа нь өмнө нь ажиглаагүй ургамлаа нэмж бүртгэснээс гадна цаг уур, хур тунадасны нөлөөгөөр нэг наст буюу хөл газрын ургамал нэмэгдсэнтэй холбоотой юм.

№	Газар усны нэр	Хэв шинж, хэвшил	Ургамлан нөмрөгийн төрх байдал						
			Зүйлийн тоо (10м2 -д)	1 м2 т-д зүйлийн тоо	Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар , %	Хад, чулуу , %	Ургац, ц/га
1	Жавхлант баг, Баруун ханан, Тэсэгт, Гүн хар	Шар мод-баглуур, бударганат, холимог сөөгт, буйлст (75-235-243/У-VII-2-2; Н-IV-2-4; Н-V-3-1)	11-21	4-6	29.3	0.8	41.3	29.4	2.22
2	Гавилууд баг, Бударгана.	Монгол өвс –баглуурт, хармагт, дэрс - бударгана-хармагт (149-238-225/ Ц-I-1-6; Н-IV-3-1; Н-III-3-6)	8	4-5	25.9	1.0	52.3	21.8	1.98
3	Гавилууд баг, Сүүл Ухаа.	Монгол өвс-боролзойт, Монгол өвс -шавагт, Таана-монгол өвст (144-145-158/ЦХ-I-1-3; ЦХ-I-1-4; ЦХ-I-2-2)	8	3-6	24.2	-	61.4	14.4	1.0
4	Ханбогд сумын 1, 2-р цэг.	Тэсэгт, тэсэг -шаваг-харганат, тэсэг-хойргот (162/ЦХ-I-3-2)	13	3-5	35.6	1.4	59.8	4.6	3.28
5	Баян баг, Хэвтээ бор, Ухаа заг.	Бударгана-баглуурт, хотирт (166-177/Ц-I-1-4; Ц-I-2-5)	10-13	4-5	28.2	0.6	48.2	23.6	4.2
6	Баян баг, Билгэх, Шар хошуу.	Баглуур-таанат, бударгана-баглуурт - хойргот-хармагт (165-166а/Ц-I-1-2; Ц-I-1-4)	13	3-5	20	1.2	49.4	30.6	2.02
7	Гавилууд баг, Аргалантын зоо, Эхэн халив.	Бор бударгана-таана-баглуурт (166/ Ц -I-1-4)	15	3-5	24.6	1.0	60.4	15.0	0.6

№	Газар усны нэр	Хэв шинж, хэвшил	Ургамлан нөмрөгийн төрх байдал						
			Зүйлийн тоо (10м2 -д)	1 м2 т-д зүйлийн тоо	Ургамлын бүрхэц, %	Олирогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар , %	Хад, чулуу , %	Ургац, ц/га
8	Номгон баг, Хадан хошуу, Зүүн замт	Улаан бударгана-бударгана, хотирт, дэрс-бударгана-хармагт (168 -177-236/ Ц -I-1-6; Ц -I-2-5;H-IV-3-1-4)	16	3-6	30.3	1.0	63.0	6.7	2.56
9	Номгон баг, Бүйлстийн ам	Холимог сөөгт(180 -181;/ Ц -I-2-8; У -VII-2-9	14	3-5	29.4	0.4	49.1	23.5	1.74
10	Номгон баг, Баруун заг	Бударганат –баглуур-үмхий өвст, Хармаг-бударганат(166-169-239/Ц-1-1-4; 169/Ц-I-1-7; H-IV-3-4)	15	3-5	25.3	1.8	45.0	27.7	2.62
Дундаж ургац, ц/га			2016						3.578
			2022						2.3

Бэлчээрийн ургамлын төрөл

№	Ургамлын төрөл	Талбай, га
1	Монгол өвс–баглуурт, Монгол өвс-боролзойт, Бударганат-дэрс -хармагт	5025.8
2	Монгол өвс-боролзойт, Монгол өвс-баглуурт, Монгол өвс-шавагт, холимог сөөгт	66388.5
3	Баглуур-монгол өвст, тэсэг, шар модот	1889.0
4	Шар мод-баглуур, дэрс -хармагт, холимог сөөгт	108688.2
5	Шар мод-баглуур, бударганат, холимог сөөгт, бүйлст	197978.7
6	Монгол өвс-боролзойт	2751.5
7	Тэсэгт, тэсэг -шаваг-харганат, тэсэг-хойргот	23818.4
8	Бударгана-баглуурт, загтай	17792.3
9	Баглуур-таанат, бударгана-баглуурт -хойргот	61038.6
10	Бор бударгана-таана-баглуурт	202564.6
11	Улаан бударгана-холимог сөөгт	80645.4
12	Шар мод -бударганат, холимог сөөгт, сийрэг загт	11350.5
13	Улаанбударгана-бударганат, Баглуур –бударганат, бударгана-дэрс-хармагт	303929.5
14	Холимог сөөгт, сийрэг загт	152271.5
15	Бударганат -баглуурт, Хармаг-бударганат, сийрэг загтай	35241.3
16	Тэсэг -хазаар өвст, тэсэг-хойргот	55907.3
17	Хармагт	23927.5
18	Заг	145232.9
Нийт		1496441.4

Багуудын 2022 оны олон наст ургамлын суурь хоорондын хоосон зайг харьцуулахад 200 см-ээс дээш байх тохиолдол нийт хэмжилтийн ихэнх хувийг эзэлж байгаагаас Баян баг хамгийн их 89,7%, Номгон баг 86,9%, Жавхлант 75,7%, Гавилууд хамгийн бага 42,9%-ийг

эзэлж байна. Эндээс үзэхэд Баян баг, Номгон, Жавхлант (75,7-89,7%) багуудын бэлчээрийн судалгааны талбайн ойр орчим хэт сийрэг ургамалжилттай гэдгийг илэрхийлж байна. Харин Гавилууд баг бусад багуудаас ургамал хоорондын зай бага ургамалжилт элбэг байлаа.

Ургацын дүн

Судалгааны 18 цэг тус бүрт шугаман зүсэлтийн дагуу санамсаргүй аргаар 5 давталттай 1м² хэмжээтэй жаазанд сууриараа багтах ургамлыг газрын хөрснөөс 1см үлдэх түвшинд хагд, ногоогоор ялган хайчлан авч, сүүдэр газар тавьж, агаарын хуурайд хатаан 0,01 нарийвчлалтай жингээр хуурай жинг жигнэж тогтоов.

Баг	Цэгийн нэр	Ургамлын зүйл		Ургац кг/га	Хувь
		Монгол нэр	Латин нэр код		
Баян	Билгэх	Ахар навчит баглуур	ANBR	16.7	94.3%
		Гейманы бөөдий	ARHE	1.0	5.7%
	Хэвтээ бор	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	2.0	2.0%
		Ахар навчит баглуур	ANBR	10.0	9.9%
		Гейманы бөөдий	ARHE	3.0	3.0%
		Хойрог харгана	CARBR	40.0	39.6%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	21.0	20.8%
		Харлаг үмхий өвс	PENI	25.0	24.8%
		Ахар навчит баглуур	ANBR	18.0	53.2%
	Шар хошуу	Зүүнгарын хазаар өвс	CLSO	2.3	6.9%
		Сөөгөн сэдэргэнэ	COFR	5.0	14.8%
		Өргөст ортууз	OXACI	5.0	14.8%
		Говийн хялгана	STGB	3.5	10.4%
	Ухаа заг	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	1.0	1.5%
		Ахар навчит баглуур	ANBR	15.4	22.7%
		Гейманы бөөдий	ARHE	3.0	4.4%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	5.0	7.4%
		Зүүнгарын бутаргана, Улаан бутаргана	RESO	15.0	22.1%
		Бор бударгана	SAPA	28.5	42.0%
Гавилууд	Аргалтын зоо	Говийн шарилж	ARGB	2.5	24.4%
		Гейманы бөөдий	ARHE	3.0	29.3%
		Бор бударгана	SAPA	4.8	46.3%
	Бударгана	Төлөгчдүү боролз	AJAC	6.0	13.5%
		Монгол сонгино, Хөмөл	ALLPO	12.0	27.0%
		Ахар навчит баглуур	ANBR	11.3	25.5%
		Говийн шарилж	ARGB	3.5	7.9%
		Гейманы бөөдий	ARHE	5.3	11.8%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	6.3	14.3%
	Эхэн халив	Ахар навчит баглуур	ANBR	14.0	38.2%
		Гейманы бөөдий	ARHE	3.0	8.2%
		Бор бударгана	SAPA	19.7	53.6%
	Сүүл ухаа	Төлөгчдүү боролз	AJAC	8.3	48.8%
		Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	3.0	17.7%
		Харлаг үмхий өвс	PENI	3.0	17.7%
		Говийн хялгана	STGB	2.7	15.8%

Баг	Цэгийн нэр	Ургамлын зүйл		Ургац кг/га	Хувь
		Монгол нэр	Латин нэр код		
Ханбогд сум	Ханбогд сум 1 дэх цэг	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	3.3	3.2%
		Ахар навчит баглуур	ANBR	24.0	23.4%
		Гейманы бөөдий	ARHE	1.0	1.0%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	6.3	6.1%
		Аммоны сэдэргэнэ	COAM	4.0	3.9%
		Өргөст ортууз	OXACI	31.0	30.2%
		Хулан хойрго, Монгол хойрог	POMGL	25.5	24.9%
		Говийн хялгана	STGB	3.5	3.4%
		зэлэн зангуу	TRTE	1.0	1.0%
		Шар хотир	ZYXA	3.0	2.9%
	Ханбогд сум 2 дахь цэг	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	3.0	10.3%
		Гейманы бөөдий	ARHE	3.4	11.7%
		Орог тэсэг	EUCE	10.0	34.4%
		Харлаг үмхий өвс	PENI	9.0	31.0%
		зэлэн зангуу	TRTE	3.7	12.6%
Жавхлант баг	Баруун ханан	Төлөгчдүү боролз	AJAC	6.0	30.0%
		Гейманы бөөдий	ARHE	1.0	5.0%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	1.0	5.0%
		Умардын оготны сүүл	ENBO	3.0	15.0%
		Өргөст ортууз	OXACI	9.0	45.0%
	Дайчингийн заг	Божмог шарилж	ARANE	19.0	46.6%
		Ямаан шарилж	ARSC	21.8	53.4%
	Гүн хар	Ахар навчит баглуур	ANBR	16.7	52.2%
		Гейманы бөөдий	ARHE	4.8	14.9%
		Говийн хялгана	STGB	10.5	32.9%
	Тэсэгт	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	2.0	11.3%
		Говийн шарилж	ARGB	1.0	5.7%
		Гейманы бөөдий	ARHE	2.0	11.3%
		Говийн хэрээн нүд	ASGO	1.0	5.7%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	2.0	11.3%
		Хулан хойрго, Монгол хойрог	POMGL	9.7	54.7%
Номгон	Баруун заг	Харлаг үмхий өвс	PENI	65.5	100.0 %
	Бүйлстийн ам	Төлөгчдүү боролз	AJAC	2.7	7.3%
		Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	2.0	5.4%
		Таана	ALLPO	3.0	8.2%
		Ахар навчит баглуур	ANBR	6.0	16.4%
		Цацагт бэрээмэг	ARFI	3.0	8.2%
		Гейманы бөөдий	ARHE	2.0	5.4%
		Төвд заан таваг	ERTI	1.0	2.7%
		Баг хуш хамхаг	HAGL	1.0	2.7%
		Алтайн согсоот	HEAL	9.0	24.5%
		Говийн хялгана	STGB	7.0	19.1%
	Хадан хошуу	Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	1.0	1.4%
		Ахар навчит баглуур	ANBR	22.0	31.7%

Баг	Цэгийн нэр	Ургамлын зүйл		Ургац кг/га	Хувь
		Монгол нэр	Латин нэр код		
	Цэгийн нэр	Гейманы бөөдий	ARHE	1.3	1.9%
		Сибирь хармаг	NISB	18.0	26.0%
		Бор бударгана	SAPA	27.0	38.9%
		Монгол сонгино, Хөмөл	ALLMGL	1.0	2.4%
	Зүүн замт	Ахар навчит баглуур	ANBR	18.8	45.0%
		Зүүнгарын хазаар өвс	CLSO	5.0	12.0%
		Бор бударгана	SAPA	15.0	35.9%
		Говийн хялгана	STGB	2.0	4.8%

Ханбогд суман дахь бэлчээрийн даац, бодит чадавх.

Номгон баг **442439.80 га** бэлчээрийн талбайтай, зуны дээд ургац 2.4 ц/га, малд идэгдэх бодит нөөц нь 662106. центнер, тухайн бэлчээрт зун-намрын улиралд 211 хоногт, өвөл хаврын улиралд 154 хоногт хонин толгойд шилжүүлснээр 139537.6 тооны мал бэлчээрлэх даацтай байна.

Гавилууд баг **197860.74 га** бэлчээрийн талбайтай, зуны дээд ургац дунджаар 2.3 ц/га, малд идэгдэх бодит нөөц нь 189868.7центнер, тухайн бэлчээрт зун-намрын улиралд 187, өвөл-хаврын улиралд 178 хоногт хонин толгойд шилжүүлснээр 40014.5 тооны мал амьтан бэлчээрлэх даацтай байна.

Жавхлант баг **484262.75 га** бэлчээрийн талбайтай, зуны дээд ургац 2.44 ц/га, малд идэгдэх бодит нөөц нь 1151553.1центнер, тухайн бэлчээрт зун-намар ба өвөл хаврын улиралд хонин толгойд шилжүүлснээр 163814 тооны мал амьтан бэлчээрлэх боломжтой байна.

Баян баг **216904.26** бэлчээрийн талбайтай, зуны дээд ургац 2.437 ц/га, малд идэгдэх бодит нөөц нь 477106.8центнер, тухайн бэлчээрт зун-намар ба өвөл хаврын улиралд хонин толгойд шилжүүлснээр 67870.8 тооны мал амьтан бэлчээрлэх боломжтой байна.

Хайрхан баг **8929.78га** бэлчээрийн талбайтай, зуны дээд ургац 2.3 ц/га, малд идэгдэх бодит нөөц нь 0.6 центнер, тухайн бэлчээрт зун-намар ба өвөл хаврын улиралд хонин толгойд шилжүүлснээр 2720.9 тооны мал амьтан бэлчээрлэх боломжтой байна.

Ханбогд сумын хэмжээнд зун-намар ба өвөл хаврын бэлчээрт даацаас (экологийн чадавх) нь Гавилууд багт 74999.5 –н хониор, Баян багт 45947.2 –н хониор илүү ачаалсан буюу бэлчээрийг 227.4%, 107.7% ашиглаж, даац 3.8 ба 1.8 дахин хэтэрсэн байна. Харин Жавхлант ба Хайрхан багийн бэлчээр хэвийн ашиглалттай, Номгон багийн нутагт даац хэтрээгүй, 53.6% ашиглах нөөц бүхий алсын бэлчээр нутаг байна.

Багийн нэр	Бэлчээрийн талбай, га	ургац, ц/га	Бэлчээрийн тэжээлийн нөөц /ц/га/	Малд идэгдэх бодит ургац, ц/га	Бэлчээрийн даац /хонин толгой/	Бэлчээрийн ачаалал /хонин толгой/	Даац хэтрэлт
Номгон баг	442439.80	2.4	980897.9	662106.1	139537.6	8470	131067.6
Гавилууд баг	197860.74	2.3	281287.0	189868.7	40014.48	115014	-74999.5
Жавхлант баг	484262.75	2.34	1151553.1	777298.4	163814.2	105852	57962.2
Баян баг	216904.26	2.37	477106.8	322047.1	67870.8	113818	-45947.2
Хайрхан баг	8929.78	2.3	19127.2	12910.89	2720.9	1657	1063.9

Бэлчээрийн даац хэтрэлтийн үзүүлэлт

Багийн нэр	Бэлчээрийн даац /хонин толгой/	Бэлчээрийн ачаалал / хонин толгой/	Даац хэтрэлт	Бэлчээр ашиглалт %	Ашиглалтын эрчим	Илүү ашиглалт	Даац хэтрэлт
Номгон баг	139537.6	8470	131067.6	6.1%	60%	-53.9%	Хэтрээгүй
Гавилууд баг	40014.48	115014	-74999.5	287.4%	60%	227.4%	3.8 дахин хэтэрсэн
Жавхлант баг	163814.2	105852	57962.2	64.6%	60%	4.6%	Хэвийн
Баян баг	67870.8	113818	-45947.2	167.7%	60%	107.7%	1.8 дахин хэтэрсэн
Хайрхан баг	2720.9	1657	1063.9	60.9%	60%	0.9%	Хэвийн

Хүснэгтээс харахад бэлчээр судлаач Н.Лхагжавын бэлчээр ашиглалтын эрчим 45-60 хувь байх нь тохиромжтой бэлчээрийн ургамал байгалийн аясаар нөхөн төлжих нөхцөл бүрддэг гэж тодорхойлсонтой харьцуулахад бэлчээрийн даац Жавхлант, Хайрхан багуудад хэвийн, Гавилууд багт 3.8 дахин, Баян багт 1.8 дахин хэтэрсэн, харин Номгон багт хэтрээгүй, 53.9% ашиглах боломжтой нөөц бүхий алслагдсан бэлчээр байна.

1. Ханбогд суманд дундаж, нам уулын, цөлөрхөг хээрийн, говийн цөлийн, нам хотосын 9 ангийн 17 төрлийн бэлчээр байгааг илрүүлж, ургамалжлын зургийг бэлчээрийн нэгж талбарт хуваах аргаар зохиож, бэлчээрийн төрлөөр га талбайг гаргаж, бэлчээрийн даац багтаамж бодоход ашигласан.

2. Ханбогд сумын бэлчээрийн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлын хувьд нийт бүлгэмдлүүдийн дунджаар 10м² талбайдаа 9-21 зүйлтэй, 1м² талбайд 3-6 зүйл ургамалтай, Баглуур, Монгол өвс, шар мод, хотир, таана, бударгана, тэсэг зонхилсон, доройтсон бэлчээртээ Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.), Харлаг үмхий өвс (*Peganum nigellastrum* Bge.), Толгодын бударгана (*Salsola collina* Pall.), *Ktze.*), бусад хөл газрын ургамал түрж ургасан, 20.0-36.0% тусгаг бүрхэцтэй, ургац 2022 оны байдлаар 0.6-4.2 ц/га байна.

3. Бэлчээрийн ургамлан нөмрөгийн 2022 оны төлөв байдлыг үнэлгээг олон улсын шугаман цэгийн аргаар (LPI) гүйцэтгэж DIMA 5.5 программаар бодож үр дүнг гаргасан нь

шинэлэг талтай боловч бэлчээрийн урт хугацааны хяналт, шинжилгээний цэгүүд нэг нэгж талбар буюу нэг төрлийн бэлчээр дээр 2-3 цэг байрлаж байгаа нь сайн боловч зарим бэлчээрийн нэгж талбарыг төлөөлөх цэг дутмаг байгааг анхаарах хэрэгтэй байна.

4. Бэлчээрийн даац Жавхлант, Хайрхан багуудад хэвийн, Гавилууд багт 3.8 дахин, Баян багт 1.8 дахин хэтэрсэн, харин Номгон багт хэтрээгүй, 53.9% ашиглах боломжтой нөөц бүхий алслагдсан бэлчээр байна.



Тоорой модны хяналт-шинжилгээ



Тоорой мод (*Populus diversifolia*) нь Монгол улсын Улаан номд нэн ховор статусаар бүртгэгдсэн төдийгүй говь цөлийн унаган ургамал юм. Монгол орны Өмнөговь аймгийн Номгон сумын Баянгол, Цагаан дэрст, Баяндалай сумын Жааханшанд, Мухарын ам, Өвөрхангай аймгийн Богд сумын нутаг Аж богд, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг Эхийн гол, Дорноговь аймгийн Мандах сумын нутаг Сүйхэнтийн уул зэрэг газруудад тоорой

ургаж байна. Үүнээс говийн бүсийн 30 орчим баянбүрдийн хүрээнд 53 мянган тоорой бүртгэгдсэн. Өмнөговь аймгийн Ханбогд суманд тоорой модны хэд хэдэн популяц бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс хамгийн том нь Уртын голын тооройн төгөл юм. Сүүлийн жилүүдэд байгаль, цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор Тоорой модны тархац хумигдан, үрээр ургах нөхцөлгүй болж, хаврын цагт залуу тооройн мөчрийг мал, амьтан ихээр идэж, гэмтээдэг тул байгалийн аясаар сэргэн ургаж чадахгүй голдуу хөгшин тооройнууд үлддэг. Иймээс Уртын гол, Хөх дэлийн тооройг мал, амьтнаас хашиж хамгаалах, хяналт судалгаа, мониторингийн ажлыг урт хугацаанд хийх шаардлагатай байгаа.

Уртын голын тооройн мониторингийн ажил

Уртын голын тооройн төглийн судалгааг 2020 оны 7 сард эхлүүлэхдээ хашсан болон хашаагүй 5 дээж талбай тус бүр 6 ширхэг тоорой модыг тэмдэглэн өндрийн хэмжилтийг хийсэн. Гэвч их хэмжээний үерийн улмаас хашааны гаднах зулзаган 30 орчим тоорой мод үерт урссан тул 2021 оны 5-р сард хашааны гадна шинээр 2 талбайг сонгож судалгаа хийсэн ч устаж алга болсон. Иймээс бид зулзаган тоорой модыг үерээс хамгаалах зорилгоор нэмэлт эргийн ажлыг гүйцэтгэсэн. 2022 онд хашааны доторх 5 дээж талбайн нийт 26 ширхэг зулзаган тоорой модны мониторингийг 4-10 сард сар бүрийн 15-нд, хяналтын мониторингийг улиралд 1 удаа буюу 3 удаа хийсэн. Хашааны дотор болон гадна тус бүр гурван залуу тоорой мод сонгож, улирал бүр өндөр болон тойргийн уртыг хэмжихэд хашааны доторх модны өндрийн хэмжээ хашааны гаднах модны өндрийн хэмжээнээс илүү ургасан байна. Энэ нь залуу тоорой модны навч, мөчрийг тэмээ, мал идсэнтэй холбоотой юм. Хашааны дотор болон гадна тус бүр гурван бие гүйцсэн тоорой мод сонгож, улирал бүр өндөр болон тойргийн уртыг хэмжин судалгааг хийхэд модны ургалт хэвийн байв.

2021 оны 07-р сард хур тунадас их хэмжээгээр орж, хүчтэй үер урссаны нөлөөгөөр Уртын голын Тооройн төглийн эрэг нурж, хамгаалалтын хашааны гаднах тоорой мод үерт урссанаас гадна хамгаалалтын хашаа нурах аюултай нөхцөл байдал үүссэний улмаас “Мөнх ногоон галба” ТББ нь Ватиканы католик шашны төлөөлөгчийн газрын тусламжтайгаар 2021 оны 08 дугаар сарын 06-08-ны хооронд шаардлагатай техник, тээврийн хэрэгсэл, ажилчдыг түрээслэн 120 метрийн урттай нэмэгдэл эргийг хийсэн.

Хөх дэлийн тоорой модны мониторингийн ажил

Хөх дэлийн тоорой мод нь нийтдээ 3 хашаатай бөгөөд хашааны дотор 4 талбай (1 дэх хашааны дотор 2 талбай, бусад 2 хашааны дотор тус бүр 1 талбай), хашааны гадна 1 талбай нийт 5 талбайд мониторингийн ажлыг хийсэн. Хөх дэлийн тоорой модны өсөлт харилцан адилгүй байгаа нь хур тунадас буюу чийг дутагдсанаас мөн зарим мэрэгч амьтдад идэгдсэнээс болж өндөр нь буурсан байх магадлалтай юм. Учир нь хашаанд амьтны үүр байсан бөгөөд зарим тоорой дээрээсээ идэгдсэн нь ажиглагдсан юм.

“Мөнх ногоон Галба” ТББ нь 2021 оны 05 дугаар сард Ханбогд сумын Уртын гол, Хөх дэл, Хар дэл хэмээх гурван газар дахь тоорой модыг тоолоход нийт 241 ширхэг тоорой мод тоологдсон. Үүнд:

1. Уртын голд 165 ширхэг тоологдсоноос 149 мод амьд, 16 мод унасан.
2. Хөх дэлд 38 ширхэг тоорой мод тоологдсон.
3. Хар дэлд 54 ширхэг тоорой мод тоологдсон

Уртын гол, Хөх дэлийн нийт 43 ширхэг зулзаган, 12 ширхэг залуу, бие гүйцсэн 6 ширхэг нийт 61 ширхэг тоорой модонд судалгаа хийхэд Уртын голын тоорой нь илүү ургах чадвар сайтай нь ажиглагдлаа. Учир нь Уртын голын тоорой нь голын хажууд, эрэг дагуу байрлан ургадаг тул Хөх дэлийн тооройноос харьцангуй илүү чийг сайтай байх магадлалтай юм. Тоорой модыг хашаалснаар модны ургах чадвар сайжирч өндөр болон тойргийн уртын хэмжээ нэмэгдэж, тэмээ мал идэхээс хамгаалан ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх ач холбогдол бүхий ажил болсон. Бусад ургамал ч сайн ургаж, биологийн олон янз байдалд сайн нөлөө үзүүлсэн бөгөөд мэрэгчид, туулай болон шувууд үүрлэн амьдарч байна. Уртын голын тооройг үерээс хамгаалах, тоо толгойг цөөрөхөөс сэргийлэн 120м нэмэгдэл эрэг хийсэн.

Уртын голын хашаан доторх зулзаган тоорой мод хэт шигүү ургасан тул сийрэгжүүлэх зорилгоор нийт 280 суулгацыг иргэн, аж ахуй нэгжид өгч тариулсан. Ингэснээр цаашид Уртын голын тоорой модыг үндсээ булаацалдах нөхцлийг бууруулан ургах чадвар сайжирч, бусад газруудад ч суулгацаар ургуулан тооройн тоо толгойг нэмэгдүүлэх давуу талтай юм.

Ханбогд сумын Уртын гол, Хөх дэл, Хар дэл хэмээх гурван газар дахь тоорой модыг тоолоход нийт 241 ширхэг тоорой мод тоологдсон. Уртын голын тоорой модыг хашсан талбайд 2021 оны 05-р сарын 13-нд нэг малчин хашааны цоожийг эвдэн мал оруулсан зөрчил гарсан тул “Мөнх ногоон галба” ТББ уг зөрчлийг холбогдох байгууллага, ажилчдад мэдэгдэн хамтарч хяналт тавьж, ажилласнаар Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга Х.Нэхийт 2021 оны 05 дугаар сарын 20-ний өдөр А/147 дугаар “Мал бэлчээхийг хориглох тухай” захирамж гарсан нь цаашид малчид Уртын гол, Хөх дэлийн тооройн төгөлийн хашаанд мал оруулахгүй байх нөхцөлийг хангаж өгсөн.

Тоосны хяналт шинжилгээ



Агаарын чанар, тэр дундаа тоосжилтийг хянах нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад нэн чухал үйл ажиллагаа юм

Ханбогд сумын нутагт нийт таван байршилд тоосны хяналт шинжилгээний цэгийг байгуулаад байна. Хяналт шинжилгээний цэгийн гурав нь Ханбогд сумын ойролцоо, тухайлбал: Сум 1 цэг нь сумын төвийн зүүн талд, Сум 2 цэг нь сумын төвийн баруун талд, Сум 3 нь Уужим-Од компанийн

уурхайлах талбайн зүүн талд байрласан. Үлдсэн хоёр цэг нь Оюутолгой уурхайн талбайн орчимд байрлаж байна. Зам 1 нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн нүүрсний замаас Оюутолгой уурхай хүртэлх 13 км замын хажууд, Зам 2 цэг нь Оюутолгой уурхайн зүүн талд тус тус байрладаг.

Тоосны хяналт шинжилгээгээр нарийн ширхэглэгт тоосны хоногийн дундаж агууламж Сум1 цэгт 0.03 мг/м³ - 0.497мг/м³, Сум2 цэгт 0.01 мг/м³ - 0.042мг/м³, Сум3 цэгт 0.001 мг/м³ - 0.0488 мг/м³, Зам1 цэгт 0.05 мг/м³ - 0.048 мг/м³, Зам2 цэгт 0.03 мг/м³ - 0.001 мг/м³, Сумын төв 0.05 мг/м³ - 0.571 мг/м³ хооронд хэлбэлзэж байв. Нарийн ширхэглэгт тоосны хоногийн дундаж агууламж нь Монгол улсын агаарын чанарын стандартад заасан 0.050мг/м³ хэмжээнээс хэтрэх ёсгүй. Энэхүү стандарт шаардлагатай харьцуулахад хяналт шинжилгээний цэгүүдэд нарийн ширхэглэгт тоосны агууламж Сум1, Сум2, Уужим од, Зам2, Зам1 цэгүүдэд стандартын шаардлагыг хангасан байна. Харин Сумын төвийн цэгт 4-р сар зөвшөөрөгдөх хэмжээнээс 0.521 мг/м³-аар давсан байна. Хэдийгээр бусад цэгүүдэд стандартад нийцсэн хэдий ч Сум1, Уужим од, зам2 цэгт зөвшөөрөгдөх хэмжээнд тун дөхсөн тоосжилттой тохиолдолдлууд цөөнгүй байв. Хяналтын станцын мэдээгээр хэмжилт хийх үеийн нарийн ширхэглэгт тоосны дундаж агууламж 0.01 мг/м³ – 0.0,098 мг/м³ байв.

Тоосны хяналт шинжилгээг 2020 оны II улирлаас шинэ төвшинд хэрэгжүүлж эхлэв. Энэхүү тайлан нь тус хяналт шинжилгээний 2021 онд хийгдсэн хэмжилтийн мэдээг нэгтгэсэн

тайлан болно. Ковид-19 цар тахалын нөхцөл байдлаас үүдсэн хөл хориотой холбоотойгоор III, IV, VI, VII саруудад хэмжилт хийгдээгүй болно.

Тоосны хяналт шинжилгээгээр нарийн ширхэглэгт тоосны хоногийн дундаж агууламж 2021 оны үр дүн Сум1 цэгт 0.006 мг/м³ - 0.048 мг/м³, Сум2 цэгт 0.003 мг/м³ - 0.030 мг/м³, Сум3 цэгт 0.003 мг/м³ - 0.018 мг/м³, Зам1 цэгт 0.007 мг/м³ - 0.059 мг/м³, Зам2 цэгт 0.001 мг/м³ - 0.045 мг/м³ хооронд хэлбэлзэж байв. Нарийн ширхэглэгт тоосны 2022 оны хоногийн дундаж агууламж Сум1 цэгт 0.03 мг/м³ - 0.497мг/м³, Сум2 цэгт 0.01 мг/м³ - 0.042мг/м³, Сум3 цэгт 0.001 мг/м³ - 0.0488 мг/м³, Зам1 цэгт 0.05 мг/м³ - 0.048 мг/м³, Зам2 цэгт 0.03 мг/м³ - 0.001 мг/м³, Сумын төв 0.05 мг/м³ - 0.571 мг/м³ хооронд байв.

Хэмжилтийн үр дүнг ерөнхийд нь авч үзвэл Ханбогд сумын зүүн талд байрлах Сум1 цэгт болон Таван толгой нүүрсний замаас Оюу толгой уурхай чиглэлийн сайжруулсан шороон замын дагууд байрлах Зам1 цэгт хэмжигдсэн тоосжилтын хэмжээ бусад цэгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр тоосжилттой байна. Ханбогд сумын зүүн талд буюу зонхилох салхины доод талд байрлах Сум1 цэгт хэмжигдсэн тоосны агууламж бусад цэгүүддэх тоосны дундаж агууламжаас харьцангуй өндөр байгаа нь сумын төвийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсдэг гэж үзэж болох талтай байна. Зам1 цэгийн хувьд маргаангүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт гол эх үүсвэр гэдэг нь тодорхой билээ. Тус замыг сар бүр засварлаж, хоногт 1-3 удаа усалгаа хийхээр төлөвлөн ажилладаг хэдий ч энэ жилийн хувьд Ковид- 19 цар тахлын үеийн хөл хориотой холбоотойгоор III, IV, V, VII саруудад усалгаа огт хийгдээгүй. Харин VIII сараас усалгааг дахин эхлүүлж, IX сард давтамжийг 4-5 дахин нэмэгдүүлсэн. Хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор усалгааны тоог X, XI саруудад тодорхой тоогоор бууруулсан.

Таван толгойн нүүрсний замаас Оюу толгой уурхайн хойд хаалга хүртэлх сайжруулсан шороон замд тоос дарах тусгай бодис ашиглах ажил

Таван толгойн нүүрс тээврийн засмал замаас Оюу толгой уурхай хүртэлх шороон (ТТОТ зам) замд тоос дарагч бодис цацах ажил явагдаж байна. Тоос дарах зорилгоор Лигносультфонат нэртэй урвалжийг сонгон, худалдан авч ашиглаж байна. Тус бодис нь модноос ялгаж авдаг лигнин хэмээх барьцалдуулагч шинж чанар бүхий бодисоор үйлдвэрлэдэг, байгальд ямар нэгэн хор нөлөөгүй, ээлтэй бүтээгдэхүүн юм. Замын дагууд бүрэн цацалт хийхийн өмнө бодисын үр ашгийг тодорхойлох зорилгоор Оюу толгой уурхайгаас баруун зүгт 3.3км хэсэгт (1-р хэсэг) туршилтын ажлыг 2022 оны 4 сард хийж гүйцэтгэсэн. Туршилтыг замын зорчих хэсгийн нэгж талбайд 0.7л/м² бодис хуримтлагдахаар тооцож хийсэн.

- Хамтарсан тоосны хяналт шинжилгээний 2020 оны 2-р улирлын буюу 5-р сарын 18-20 өдрүүдэд хийсэн хэмжилтийн үр дүнгээр Ханбогд сум болон Оюу толгой уурхай орчимд Агаар дахь нарийн болон бүдүүн ширхэглэгт тоосны агууламж Монгол улсын агаарын чанарын стандартад еранхийдөө нийцэж байгаа боловч ОТ арын зам хэвийн хэмжээнээс илүү тоос ажиллагдлаа.Цаашид энэ замын асуудал дээр хоёр тал анхаарах шаардлагатай байх.
- Ханбогд сумын зүүн талд буюу зонхилох салхины доод талд байрлах Сум1 цэгт хэмжигдсэн тоосны агууламж бусад цэгүүдтэй харьцуулахад мөн харьцангуй өндөр байгаа нь сумын төвийн хөдөлгөөнөөс үүсдэг бөгөөд оршин суугчдын эрүүл амьдрах нөхцөлд аюул учруулж байна. Сумын төвийн замыг хатуу хучилтаар хучвал тоосжилтын хэмжээ буурна.

- Мөн байгаль орчныг хамгааллах чиглэлээр хамтран ажиллах 2022 оны төлөвлөгөөний дагуу энэ оны 3 сараас ханбогд сумын төвд 1 цэг шинээр нэмэж хэмжилт хийсэн.
- 2022 оны нарийн ширхэгт тоосонцорын үр дүнгээс хархад 5-р сарын хэмжилт Уужим од 0,482мг/м3, 4-р сард 0,480мг/м3, 4-р сар Сумын төв 0,571мг/м3, 5-р сард Сум1 0,475мг/м3, 6-р сар Сум1 0,497мг/м3 стандартаас өндөр байлаа.
- 2022 оны том ширхэгт тоосонцорын үр дүнгээс Уужим од 4-р сар 0,489мг/м3, мөн 5-р сард 0,489мг/м3, Сум1 0,482мг/м3 ба 6-р сард 0,563мг/м3 стандартаас өндөр байлаа.

ГТЗ-ийн санаачилгаар хэрэгжүүлсэн төслүүдэд зарцуулсан санхүүжилтийн дүн (2022 он)

№	Хийгдсэн ажил	Дүн (сая.төг)
1	Оюутны тэтгэлэг/ малчин	28,0 сая
2	Хөөн хэлэлцэх 160 өрх	49,0 сая
3	“Ундай” ахмадын төсөл	97,7 сая
4	Гар худаг засварын ажил	164,1 сая
5	“Мөнх ногоон галба” ТББ	331,2 сая
6	Эрүүл малчин хөтөлбөр 1, 2, 3	234,0 сая
7	Гар худагт нарны толь суурилуулах ажил	304,4 сая
8	Хороо бууц засвар	45,1 сая
9	Инженерийн хийцтэй худаг	-
10	Мал нядлах үйлдвэр	1,8 сая
11	Нарийн бичгийн байгууллага	60,2 сая
12	Малчдын төлөөллийн үйл ажиллагааны зардал	25,6 сая
13	Тогтвортой амьжиргааг дэмжих төслийн нэмэлт санхүүжилт	146,3 сая
Нийт		1,487,4 сая